

Г.Батболд<sup>1</sup>✉

<sup>1</sup> ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

### Татарын тамганы тухайд

**Товчлол.** Монголын түүхийн Түрэг, Уйгурын үеийн Татар аймгуудын бичгийн сурвалж ховор тул тэдний талаарх цөөн хэдэн судалгааг эс тооцвол өнөөг хүртэл тодорхойгүй хэвээр байна. Тиймээс Монгол улсын нутгаас илэрч олдоод буй тухайн үеийн тамгануудад харьцуулсан судалгаа хийхэд зарим бүлгүүд тодорч харагдаж байна. Монголын Дорнод бүсэд буй тамгуудаас Татар аймгийн тамгуудыг тодруулсанаар археологийн зарим дурсгалуудыг өөрөөр тайлбарлаж болох юм. Өөрөөр хэлбэл Хятадын Тан улсад тушааж байсан адууны дунд Татаби нарын адуунд Татар тамгууд хамтаар тэмдэглэгдсэн байна хэмээн үзлээ.

**Түлхүүр үгс:** *Tatar, Түрэг, Уйгур, аймгийн тамга, адууны тамга, Татар тамга, Татаби*

G.Batbold<sup>1</sup>✉

<sup>1</sup>Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

### Regarding the Tamghas of the Tatars

**Summary.** The Turkic-Uyghur period stamped stele located in the eastern region of Mongolia are intriguing. Three tamghas discovered by doctor Bayar D. in 1986 in Khundlun Khavtsal (gorge) of Dariganga Sukhbaatar province are genuine Tatar tamghas. These seals, found in the horse tamghas of Tang Hui Yao's nomads, among the horses given by the Tatabi, indicates that these tamghas may be related to the Tatars. It is also depicted in a collection of tamghas carved on a rock concerning war and great Khuraltai related to the Turkic-Uyghur period.

**Keywords:** *Tatar, Turkic, Uyghur, tamghas, horse seal, Tatar tamghas, Tatabi*

### Удиртгал

Монгол нутагт Түрэг, Уйгурын үеийн тамга тэмдэг бүхий дурсгал арвин билээ. Эдгээр тамгуудыг ажиглаж байхад тэдний голлох дурсгалд тэр бүр дүрслэгдээгүй зарим нэгэн онц ялгарахуйц тамгууд байгаа нь ажиглагддаг. Жишээ нь Д.Баяр гуай 1985 онд Сүхбаатар аймгийн нутагт хээрийн судалгааны үеэр илрүүлэн зургаар баримтжуулсан гурван тамга нэлээд анхаарал татаж байна. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг Хөндлөн хавцал хэмээх газраас тамга илрүүлсэн бөгөөд эсрэг харсан саран дороо уруу харсан сартай, чагт, онгинд чагттай “☉, ×, ⊗” гэсэн ийм хэлбэртэй гурван тамга байна [Монголын археологи 2016: 361]. (Зураг 1) Эдгээр тамга хэдий үеийн тамга бэ? Зүүн бүсээс Монголын үеийн хүн чулуудтай ойр бүс нутаг учир Монголын үеийн тамга уу.

Монгол улсын зүүн бүсээс буюу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт Донгой Ширээн дурсгал хэмээх нэгэн Түрэгийн үеийн руни бичээс бүхий гэрэлт хөшөөт тахилын онгон илэрсэн юм. Улмаар 2013 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги уг дурсгалт газарт малтлага судалгаа хийж, хөшөө чулууны 20 гаруй хугархайг илрүүлэн, зарим хөшөөний цаасан хэв хуулгыг авч эхний уншлага хийж шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байдаг [Мөнхтулга 2015: 21-55].

Судлаач Р.Мөнхтулга, Т.Осава нар зарим хөшөөний бичээсийг цаасан хэвд тулгуурлан урьдчилсан байдлаар уншиж, 72 мөр, 3857 үсэг, 1193 үг, 86 орчим тамга байгааг тодруулан, “орд гэр минь ээ”, “ноён минь ээ”, “нутаг минь ээ” гэх үгсийн олон давтан бичсэн болохыг тайлж, үсэг зүй, хэл зүйн онцлог, тамганы хэлбэр, хавтан чулууны дүрслэл зэрэгт үндэслэн уг дурсгалыг 735-745 оны үед Түрэгийн хожуу хаант улсын, хааны дараа орох ураг төрлийн холбоо бүхий хэд хэдэн ихэс язгууртанд зориулсан дурсгал болохыг урьдчилсан байдлаар тогтоосон билээ [Мөнхтулга нар 2013].

2015-2016 онд Монгол-Японы хамтарсан “Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа” төслийн хүрээнд “Донгойн Ширээн” цогцолбор дурсгалын ерөнхий бүтэц, зохион байгуулалтыг бүрэн тодруулах, гэрэлт хөшөөнүүдийг бүртгэн баримтжуулах, эртний бичээс болон тамганы хэв хуулга авах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байдаг. Донгойн Ширээн цогцолбор дурсгалын ерөнхий зохион байгуулалт, гэрэлт хөшөөнүүдийн баримтжуулалт, уг цогцолбор анх ямар төрхтэй байсныг сэргээн зуруулах, C14 он цаг тогтоолгох ажлыг хийжээ [Эрдэнэ-Очир нар 2016: 249].

Судалгааны явцад хөшөөний 48 ш хугархай илэрсэн бөгөөд эдгээр нь өөр хоорондоо эвлэн нийлж нийт 14 гэрэлт хөшөө болсон байна. Эдгээр 14 гэрэлт хөшөөний 11 хугархай ёзоор анхны байрандаа илэрч олдсон байна. Цэцгэн хээтэй тахилын хавтан чулууг олон хэсэг болгон эвдэж, тараасан байжээ. Хамгийн өндөр 7-р хөшөө бөгөөд 6.4 м бөгөөд тус хөшөөний суурь гэх зүйл илрээгүй байна. Судлаачид тойрсон 12 хөшөөг төвлөсөн тонуулын нүхний орчим бусад хөшөөг голлон босгосон байж хэмээн үзжээ. Нийт 14 гэрэлт хөшөөнд руни бичээс, 11 хөшөөнд тамга, 2 хөшөөнд хятаны бага бичээс (хар бэх болон сийлмэл) байжээ. 11 хөшөөнд нүдээр ил үзэгдэх 17 төрлийн (дан болон үүсмэл) 79 тамга тодорхой мэдэгдэх бөгөөд зурмал дугуй (онги), гурвалжин (дором), дөрвөлжин, янгир, саран тамгыг хамгийн олон дүрсэлсэн бөгөөд өөр хэд хэдэн хөшөөнд уг тамганы салбар тамга мөн сийлсэн байжээ. Нэг хөшөөнд 1-17 хүртэлх тамга сийлэхдээ голчлон хөшөөний дунд хэсэгт дүрслэх боловч дээд, доод хэсэгт дүрслэх тохиолдол ч байна. Малтлагын явцад суваг болон талбайн бусад хэсгээс хонь, ямаа, адууны яс, шагай, ваар савны хагархайнууд харилцан адилгүй гүнээс илэрч байв. Ваар савны хагархай нь харьцангуй олон бөгөөд орц найрлага, хэлбэр төрх, хээ, шатаалт зэргээрээ ялгаатай 3-4 төрлийн хагархай хэсгүүд байна. Дээврийн ваар болон тоосгоны хагархай цөөн тоогоор илэрсэн. Он цаг тогтоох (C14) Япон улсад хийлгэхэд 79.2%-тай 654calAD-715calAD хэмээн Түрэгийн хожуу хаант улсын үе хэмээн үзсэнтэй ойролцоо гарсан байдаг.

Анх баруун хойноос зүүн өмнө зүгт хандсан дөрвөлжин хэлбэрийн суваг гарган (түүнээс гарсан шороогоор далан үүсгэсэн байсан нь тарж намхан болсон), сувагны дотор талд 12 гэрэлт хөшөөг тойруулан дөрвөлжин хэлбэртэй, тэгш хэмтэйгээр суулган тэдгээрийн голд буюу хоймор талд цэцгэн хээтэй тахилын хавтан хашлага, түүний өмнө талд энэхүү цогцолборын хамгийн өндөр хөшөөг тус тус босгож, улмаар сувгийн гадна зүүн талд нэг ширхэг зэл чулуутай ажээ. Ийнхүү байгуулахдаа төв хэсэгт босгосон хамгийн өндөр хөшөөний дор тахил тайлгын зан үйлтэй холбоотой зүйлийг тавьсан нь хожим тонуулчдын гарт сүйтгэгдсэн байна. Харин уг дурсгал X зууны 1-р хагасыг хүртэлх хугацаанд эвдэрч сүйдээгүй байжээ гэх сэтгэгдэл төрүүлдэг байна. Учир нь уг дурсгалт газарт анх 13 гэрэлт хөшөө бүхий тахилын хашлагыг цогцлоон босгосон бөгөөд хожим нь тэдгээрийн нэг дээр хятан бичгийг хар бэхээр бичиж үлдээснээр үл барам дахин нэг сийлмэл хятан бичиг бүхий хөшөөг шинээр босгосон байх бүрэн боломжтой байна. Уг дурсгалыг чухам хэдийд бүрэн сүйтгэсэн нь одоогоор тодорхой бус

бөгөөд ямар боловч XIX зууны үед дахин тонож, нүхээ булалгүй орхисон нь археологийн малтлага болон түүнээс илэрсэн олдвор хэрэглэгдэхүүн, лабораторийн үр дүнгээс тодорхой мэдэгдэнэ [Эрдэнэ-Очир нар 2016: 249]. Нутгийн иргэдийн аман мэдээ домгоос харахад “Хүзүүгүй тэмээ унасан хүүхэн буюу чөтгөр дарсан газар хэмээн хэлэлцдэг” байна. Үүнээс харахад XVIII-XIX зууны үед шашны зан үйл хийж бүгдийг нь хэмх цохисон байж болох юм.

Энэхүү дурсгал нь одоогийн байдлаар эртний Түрэгийн томоохон дурсгалууд дотроо зүүн захад орших, олон арван тамга тэмдэг, эртний түрэг, хятан бичээстэй 13 гэрэлт хөшөө бүхий сүрлэг цогцолбор дурсгал болж байгаагаараа онцлог юм.

Судлаач Р.Мөнхтулгын уншлагад авын газар, захын цэрэг зассан тухай гарч буй бөгөөд гол агуулга нь II хөшөөнд W1 “Дээд Тэнгэр минь ээ! Дайр Этүгэн минь ээ! Эл улс минь ээ! Нутаг минь ээ! Гэр минь ээ! Ноён минь ээ! Гэр минь ээ! Хүчээ өглөө би, ээ! Ноён минь ээ! Гэр минь ээ!” W2a: Ушга [Зах], Ушга Зах, авын нуруунаа (Авын Нуруунаа) хойлголжээ. Нутаг минь ээ! Захын цэрэг засуулаа би, ээ!” хэмээн дэлгэрэнгүй утга гарснаас бусд нь “орд гэр минь ээ, ноён минь ээ, нутаг минь ээ” гэх үгийг маш олон удаа давтан бичсэн байдалтай буй юм. Донгойн Ширээн дурсгал нь VIII зууны эхэн хагасын Түрэг улсын зүүн жигүүрийн улс төрийн бүлгүүд (“аймаг”, “овгууд”), Хятан, Татаби, Татар зэрэг монгол хэлтэн байсан гэгддэг аймгууд, ялангуяа Монголын дорнод нутгаар нутаглаж асан Татарын түүхийг судлах чухал баримт болохоор байна [Мөнхтулга 2015: 21-55] хэмээн дүгнэжээ. Түүний уншлага үргэлжилж буй бөгөөд урьдчилсан үр дүн юм.

Дээрх бичээсний утгаас харахад “захын цэрэг засуулаа би, ээ” хэмээн хил залгаа бүс нутгаас болгоомжилж байсныг илтгэсэн бөгөөд улс, гэрийн талаар олон дахин ерөөн гарч буй нь Түрэгийн хожуу хаант улс унаж байх үед зүүн бүсийн овог, аймаг өөрөөр хэлбэл Татаруудын холбоо өндийж ихэс дээдэстээ тахилын онгон байгуулж, анхны цэргийн ажиллагаа явуулж буй талаар бичээст дурдсан мэт байна.

Харин 2015-2016 онд Монгол-Японы хамтарсан баг Донгойн Ширээнд үргэлжлүүлэн малтлага судалгаа хийсэн юм. Уг судалгааны хүрээнд авсан хэв хуулгаас 6-р хөшөөний зүүн талын 1-р хэсэг, Хөшөө Цайдамын бичээс дээр байдагтай адил Түрэгийн язгуур гарвал болох Эшир овгийн тамга байх ба мөн өөр олон тамгыг босоогоор сийлсэн ажээ. Руни үсгийг 6-8 см өндөр, бага зэрэг бүдүүвтэр сийлсэн ажээ. Монгол хэлний орчуулга: “Хөх Тэнгэр азжаргал Билгэ Хаганы хаанчлалын үед, Би 2-р сарын 6-нд Ябгу болж, Тогуз огуз овгийн хандан цэрэг байрлуулсан”. Мөн 6-р

хөшөөний хойд талын 4-р мөр: 1- 4 мөрний төв хэсэг хүртэл 4 см орчим жижиг хэмжээтэй үсэг гүехэн сийлсэн байна. 4-р мөрний дунд хэсгээс үсгийн хэмжээ 6 см орчим болж гүн сийлэгджээ. Энэ хэсэг дуусаад түүний дараа бичсэн хэсэг нь бол гүехэн сийлж бараг мэдэхгүй болсон байна. “Би бол Тогуз Татарыг яллаа, аа, Би бол Тогуз Огуз овгийг яллаа, аа, Би бол Тогуз Огуз овгийг яллаа, аа, Би бол Тогуз Огуз овгийг яллаа, аа, Би бол Тэлис Шад (Түрэгийн хаант улсын зүүн бүсийн ханлиг, улс төр цэргийн тушаалтны цол)-д томилогдлоо, оо, Тэнгэр бурхан минь, ээ, Газрын бурхан минь, та бүхэн Надад хүч чадал хайрлаач, ээ” [Такаши Осава 2016.] хэмээн уншсан байна.

Бид хоёр тусдаа малтсан судалгааны багийн тайлан илтгэлийг нэгтгэсний эцэст Р.Мөнхтулга нарын 2-р хөшөө, Т.Осава нарын 6-р хөшөө нэг хөшөө байна. Уг хөшөөний бичээсний утга агуулгад ямартай ч Осава нарынхаар “есөн татар”, “есөн огуз” хэмээх үг гарч буй бололтой харин Түрэгийн хэн нэгэн язгууртны зүгээс бичсэн үү? Татар язгууртны зүгээс бичсэн үү? гэдэг эргэлзээтэй юм. Учир нь энэхүү хөшөөний бичээсийг илүү олон хүн уншсаны дараа иймэрхүү өнгө аястай утга байж хэмээн багтлагдахаас нэгэн хүний уншлагаар шууд авахад бэрхтэй мэдээ юм. Уг тахилын онгон Түрэгийн алтан ургийн хэн нэгэн язгууртантай холбоотой хэмээн Т.Осава үзжээ. Хэрэв энэ тийм байсан бол Орхоны хөндийн Түрэгийн ноёлох овгийнхны тахилын онгонтой нэлээд төслөг хийгдэх байсан болов уу. Түүнээс гадна Билгэ хаан, Культегин нарын тахилын онгоноос бараг илүү сүрлэг хийхийг эрмэлзсэн шинжтэй, Зүүн гарын ханлигуудын нутагт Түрэгийн алтан ургийн хүний тахилын онгон үйлдэх боломж хэр вэ? зэрэг нь Түрэг язгууртны бус хэмээн эргэлзэх шалтгаанууд олон байна. Хэрэв Түрэгийн тахилын онгон байсан бол X зууныг гартал бүтэн байх боломж хэр байх вэ? Түүнээс гадна уг тахилын цогцолборт 13 гэрэл хөшөө босгоод бүгдийг нь бичгээр дүүргэхийг зорьсон нь мөн ингэж үзэхэд хүргэж байна.

Уг гэрэлт хөшөөний бичээсний талаар Т.Осава Түрэг бичгийн дурсгал нь Хөшөө цайдам, Билгэ хааны гэрэлт хөшөө болон Налайх дахь Тоньюкукийн бичээстэй адил юм. Сийлсэн арга барил нь бага зэрэг өөр болно. Олон хөшөөнүүд дээр ижил үсэг сийлсэн байгаа нь нэг цаг үед сийлсэн хэмээн үзэж байна.

Зарим гэрэлт хөшөөний өргөн хэсэгт эхлээд 4-5 см өндөр нарийхан үсэг гадаргуун дээр сийлж, түүний дээрээс 7-8 см, 10 см-ээс ч том үсгээр сийлж бичсэн мөн түүний дээр олон тамга сийлсэн байгааг мэдэж болохоор байна. Эдгээр давхарлаж бичсэн хэсгүүдийг тайлж унших нэн

бэрхтэй юм. Энэ бичээснүүд нь унших зүйлд зориулан босгосон зүйл биш болов уу. Ялангуяа энэхүү бичээст дээд хэсгээс доод хэсэг хүртэл тойруулан үсэг сийлсэн байгаа нь үйл явдлаас илүүтэй үсгээр дүүргэх зорилготой байсныг харуулж байгаа явдал болов уу [Такаши Осава 2016]. Эл хөшөөний бичээсийг уншсан хүнд ч ийм сэтгэгдэл төрүүлсэн байдаг. Гэхдээ судлаач Т.Осава уг тахилын онгоны эзнийг Түрэгийн хожуу хаант улс 682-744 оны үеийн Билгэ хааны удмын хөвгүүнд (Ябгу) цолыг олгосон болон түүний дараагийн хаант улсын зүүн хэсгийн улс төр, цэргийн томоохон цол болох Тэлис Шад хэмээх цолыг олгосон тухай байна. Одоог хүртэл Тэлис Шад гэдэг нь бол Түрэгийн хаант улсын зүүн жигүүрийн нутаг дэвсгэрийг эзэмшиж байсан эрхтэн хэмээн үзэж болохоор байгаа боловч зүүн жигүүрийн нутгийн яг төв хэсэг нь хаана вэ гэдэг тодорхойгүй байсан юм. Донгойн Ширээн бичээсний утгаас үзвэл энэхүү газар нь тодорхой болж, цаашлаад Түрэгийн хаант улсын зүүн хэсгийн түүхийг нарийвчлан судлахад чухал дурсгалт газрын нэг болно гэдэг нь эргэлзээгүй юм. Тус бичээсний гол эзэн нь Билгэ хааны үеийн захирагчийн утга агуулсан Ябгу болж, тал нутгийн хойд талын төв хэсгээс халдан довтолсон Тогуз Огузын эсрэг цэрэг засаж, Тогуз Татартай байлдан ялж, мөн (Тэлис Шад) цол авсны дараа Тогуз Огуз болон Тогуз Татартай байлдан ялсан тухай ахин бичсэн байна. Тэгээд энэхүү бичээсийн гол дүрийн цэргийн хүч чадлыг тэмдэглэсэн ба Тогуз Огуз болон Тогуз Татартай байлдахдаа Тэнгэр бурхан, газрын бурхныг дуудаж өөрийн Бэг цолт өвөг дээдсээс өөрийн биеэр цэргийн хүч хүссэн байна.

Мөн бичээсэнд гол дүрийн өрсөлдөгч болох Тогуз Огуз болон Тогуз Татартай байлдаж ялсан тухай хэд дахин тэмдэглэсэн байна. Тогуз Татартай байлдсан тухайд жишээлбэл, Билгэ хааны гэрэлт хөшөөний 34-р мөрөнд Билгэ хааныг хаан ширээнд суухаас өмнө жил 33 настай (713 он) байх үед Монголын зүүн хэсгээс төв хойд хэсэг хүртэл халдан довтолсон Тогуз Татар болон Тогуз Огузын холбоо байгуулан ирсэн ба тухайн байлдаанд ялагдсан байдал ба тэнд Тэлис Шад-н тухай байдаггүй. Гэвч Тэлис Шад-г хамгаалалтын хүрээний зүгээс харвал энэхүү тулаанд Тэлис Шад байсан гэж үзэж болох юм [Такаши Осава 2016.] хэмээн уг тахилын онгоныг Түрэгийн алтан ургийнхантай холбон тайлбарласан байна. Ябгу цолны тухайд судлаачид хааны ургийн хүн өөрөөр хэлбэл хаан ширээ залгах том хүү хаан эрсдэх юм уу хорлогдвол төрийн удирдлагыг шууд гартаа авдаг тушаалтан юм [Напил 2009: 5-20]. Бидний үзэж буйгаар хааны хөвүүн зүүнийг захирч байсан ч тэднийг нас эцэслэхэд тухайн бүсд тахилын

онгоныг нь үйлдэж байсан байх боломжгүй мэт. Тэлис Шад зуурдаар нас эцэслэсэн ч гэсэн түүнийг өвгөдийн тахилын онгоны ойр авчирч оршоох ёстой мэт.

Р.Мөнхтулга бичээснүүдийг эртний түрэг бичгийн хэлээр туурвижээ. Дурсгалын эзэнд зориулан “орд гэр минь ээ”, “ноён минь ээ”, “нутаг минь ээ” гэх зэрэг тахилын үгсийг маш олон давтан сийлсэн байна. Ингэж цөөн үгийг олонтоо давтан бичсэн нь тэр үеийн хүмүүсийн итгэл бишрэлээс үүдэлтэйгээс гадна хөшөөг хээлэн чимэх гэсэн давхар зорилго байсан бололтой. Хөшөөдөд анх тамга сийлээд хожим нь гашуудлын үг бичжээ. Өөрөөр хэлбэл тамга, бичээсийг сийлсэн нь өөр өөр цаг хугацаанд холбогдоно. Нас барсан ихэс язгууртанд зориулсан уг тахилын онгоныг байгуулах ёслолд оролцохоор ирсэн овог аймгийн язгууртнууд хөшөөнд тамгаа сийлсэн бололтой [Мөнхтулга 2015: 21-55].

Дээрх үндэслэлүүдээс харахад Түрэгийн Эшир аймгийнханд зориулагдаагүй бол уг тахилын онгон хэнийх байж болох вэ. Тухайн үед Түрэгийн зүүн жигүүрийн бүс нутаг байсан байж болох боловч ямартай ч Түрэгийн Шадад зориулагдсан онгон биш байна. Үүнийг нэгэн баримт нь хөшөөнд бусад тамганы хамт тодоор сийлэгдсэн боловч нэлээд онцгойрох байрлалд саран тамгын хувилбар (бичмэл “х” үсэгтэй төстэй) тамгыг бараг хөшөө бүрт дүрсэлсэн байна. Энэхүү тамганы эзнийг тодруулбал тахилын онгон аль бүлэгт хамаарах дурсгал болох нь тодорч болох юм.

Тамга гэдэг зүйл тухайн бүлэгтэй шууд хамааралтай тэдний эзэмшил, эрх мэдлийг шууд илэрхийлдэг хэмээн судлаачид үздэг. Булш оршуулга, тахилын онгон, хад асганд ямар нэгэн бичээсгүй ч тамга сийлсэн байхад тухайн үеийн хүмүүс хараад хэнд хамаатай газар, хэнд хамаатай булш гэдгийг шууд л ойлгодог байсан хэмээн үзэж байна. Тиймээс ер нь зөвхөн тамга сийлсэн дурсгалыг тодруулахад аль бүлэгт хамаатай дурсгал болохыг тодруулах боломжтой хэмээн үзэж байна.

Тахилын онгоны бүтэц зохион байгуулалтаас харахад тус тахилын онгоны голлох хөшөө аль вэ? Бүх хөшөө тамгатай учир аль хөшөө нь голлох хөшөө байж болох вэ? гэх асуултууд тулгарч байна. Малтлага судалгааг 2015-2016 онд малтан гүйцэтгэсэн судлаачдын тайланд баруун талаас нь №1 хэмээн дугаарласан бол судлаач Р.Мөнхтулга нар зүүн хойд булангийн хоёр дахь хөшөө №1 хэмээх дугаартай тэмдэглэгдсэн бөгөөд зүүн хойш эргэх булангийн хөшөө №2 хэмээн дугаарлагдсан байна. Энэ нь тухайн үед бүтэн талбайгаар нээгээгүй учир ийнхүү дугаарлагдсан байж болох боловч зүүн талаас нь эхлэн дугаарлах



нь зүй ёсны эхлэл байсан хэмээн үзүүштэй. Гэвч энэ үед эхэлж илэрснээс нь дугаарласан болов уу. Хэрэв нар зөв эргүүлэн дугаарлавал гол бичээст Осава нарын №5, Р.Мөнхтулга нарын №2 хөшөө хамгийн сүүлийн буюу №14 дугаар хөшөө болно гэсэн үг. Гол бичээс бүхий хөшөө хэрэв №1 хөшөө байсан гэж үзвэл нар зөв зүүн булангаас дугаарлавал Р.Мөнхтулга нарын №2, Осава нарын №5 дугаартай хөшөө №1 хэмээн дугаарлагдвал бидний анхаарал татаж буй тамгат хөшөө №2 хөшөө болох бөгөөд тамгат бичээсний хамгийн эхнийх болох төлөвтэй байна. Ямартай ч Түрэгийн тахилын онгон болон тухайн үеийн тахилын онгонууд наран ургах зүг харж байдаг онцлогийг дагавал Р.Мөнхтулга нарын дугаарлалт хамгийн зөв эхлэл байх боломжтой юм. №2 хөшөөнд бусад хөшөөг бодвол таван тамгыг том хэмжээтэй мөн гүн сийлсэн нь бусад хөшөөнөөс нэлээд онцгойрч байгаа юм. Гэхдээ саран тамганы салаа хувилбар бараг бүх хөшөөнд буй учир мөн хөшөө бүрийг гар зургийг тодорхой харагдаж буй тамгануудын хамт хэвлэсэн учир хөшөөний дугаарлалтыг цааш Б.Цогтбаатар нарын дугаарыг дагах нь уншигч түмнийг төөрөгдөлд оруулахгүйн үүднээс ийнхүү шийдсэн болно. Хөшөөнд маш олон тамга буй бөгөөд энгийн нүдээр харагдаж буй тод тамгануудад голлон хөшөөний зургуудыг үйлдсэн байна.

#### 5-р хөшөө (1-р хөшөө Р.М)

5-р хөшөөний хойд талын гол хэсэгт, оройгоос доош 116 см-т, сууриас дээш 112 см-т, 60x27 см талбайд, 1 см өргөн зураасаар ухаж сийлсэн, маш тод 5 тамга байна. Тэдгээрийг дээрээс нь эхлэн дугаарлав.

Хамгийн дээд талд буй бичмэл “х” үсэгтэй төслүүт тамганы өргөн 11 см, өндөр 7 см.

2-р тамга 1-ийн баруун доор буй. “Иштэй”, “ө” үсгийн хэлбэртэй. “ө” үсгийн хэлбэртэй тамгын тойргийн голч 9 см, өндөр 16, “иш”-ний өндөр 7 см. 3-р тамга 1-р тамганы доор, 2-ын зүүн доор байна. Сүйх хэлбэрийн толгойтой “янгир” тамга. Үүний өндөр 27 см, өргөн 15 см. Толгой нь зүүн тийш харжээ. 4-р тамга дээрх янгир тамганы доор хойд урд хөлийнх нь завсар байна. Хавирган сар хэлбэртэй. Хоёр үзүүр нь зүүн тийш харжээ. Өндөр 6 см, өргөн 7 см. 5-р тамга. Дээрх тамгануудын хамгийн доор буй. “Эширийн янгир” тамга. Өндөр 18 см, өргөн 12 см. Эдгээр 5-н тамганаас хамгийн дээд талд буй уг тамга уг тахилын онгоны эзний тамга байж мэдэх юм. Учир 1-р хөшөөнд бусад хөшөөнд олон дахин жижгээр сийлсэн тамгануудын төлөөлөл маягтайгаар хамгийн томоор нэг доор сийлсэн бөгөөд онцлон дээд талд голлох байрлалд уг тамга буй нь ингэж үзэхэд хүргэж байна. Мөн бусад хөшөөнд уг тамгыг дээгүүр байрт сийлсэн бөгөөд Түрэгийн алтан

ураг Эширийн тамга мөн түүний салаа хэмээх сүйх янгир тамга, онгин тамганы олон хувилбар холбоотой хос саран тамга, гурвалжин тамга гэх мэт тамганууд голлон сийлэгдсэн байна.

#### 1-р хөшөө

Саарал өнгийн боржин чулуу, Хэмжээ нь 332 x 58 x 33 см. Хөшөө нь суурь хэсгээс гадна орой хэсгээрээ хоёр хугарсан байдалтай ажээ. Хөшөөний өргөн талын гадаргууг тэгшлэн 16 тамга дүрсэлжээ. Тамга тус бүр нь дунджаар 0.5-1 см өргөн, 0.5-1 см гүн ухаж сийлжээ. Хөшөөний оройд нэгэн хөндлөн зураас буй бөгөөд түүний доор дээш харсан саран тамга (иш, ширээтэй) дүрслэгдсэн байна. Түүнээс доош уруу харсан саран, гурвалжин, могой, дундаа нүдтэй сүүлтэй онги, эдиз тамга гэх мэт 14 тамга байна.

#### Судалгааны хэлэлцүүлэг

Эдгээр гэрэлт хөшөөний дийлэнхэд сийлэгдсэн мөн сийлэх бүрд хамгийн дээд байрлалд эсвэл голлох байрлал бус ч заавал бичмэл “х” үсэг мэт тамгыг бусад саран тамганы салаа хувилбарыг сийлжээ. Энэхүү бичмэл “х” үсэг мэт холбоотой хос саран тамга болон ер нь саран тамга аль бүлэгт хамааралтай вэ. Уг тамга нь одоогоор Хэнтий аймгийн Биндэр сумын Рашаан хаданд яг энэ бичмэл “х” үсэг мэт хувилбараар гурав [Пэрлээ 2012.]<sup>1</sup> байгаа бол сартай онги, ширээтэй сар гэх мэт хувилбарууд маш олон байна. Төв аймгийн Бичигт Улаан хаданд [Самашев нар 2010: 59] мөн саран тамганы хэд хэд хувилбарыг харж болохоор байгаа бол зөвхөн бусад саран тамгыг салаа салбарыг тооцохгүйгээр эл бичмэл “х” үсэг мэт тамга Хэнтий аймгийн Батширээт сумын Үзүүр Цохио [Дорж нар 1975: 36], Булган аймгийн Дашинчилэн сум, Архангай аймгийн Тайхар чулуу [Самашев нар 2010: 59], Баянхонгор аймгийн Өлзийт сумын Хийдийн гээг, Булган уул, Бууцагаан сумын Гурванмандал уулын Эхэн мандалд, Дундговь аймгийн Бага газрын чулуу [Галдан нар 2010: 174-185], Баян-Өлгий аймгийн Ачит нуур, Өвөр Монголын Сөнөд зүүн хошуу Хонгор сум Тамгат [Dalan 1999: 163], Шинжааны Айркэникэтэ [苏北海 1994: 424], Алтайн баруунтаа буюу Казахстаны гэх газруудад Түрэг, Уйгурын үеийн бусад овог аймгийн тамгануудтай цугтаа болон тусдаа сийлэгдсэн байна.

Үүнээс харахад саран тамгыг эзэмшигч аймаг нь тухайн үеийн нийгмийн харилцаанд идэвхтэй

<sup>1</sup>Рашаан хад, түүний дэргэдэх том хадан самбар, тэр хавийн хад, үхэр чулуунд цавчин сийлсэн тамгадын олонх нь Монгол даяар нэлээд дэлгэр, Халхын төв нутаг, баруун өмнөд хэсэг, их говийн умард хэсгийг хамарсныг хялбархан мэдэж болохоос гадна, Рашаан хадны байгаа газар нь эрт цагт нийт монголын сүрхий төв байсныг гэрчилж Рашаан хад хавийн хад чулуун дээрх тамга дүрс нь монгол овог аймгуудын тамганы бузгай бүрэн цуглавар гэж үзэх үндэстэй боллоо [Пэрлээ 2012: 5-43]


№	Дурсгалын нэр	Байршил	Бичмэл “Х” саран тамга	Цугтаа буй саран болон бусад тамганууд
1	Рашаан хад	Хэнтий, Биндэр		
2	Донгойн Ширээ	Сүхбаатар, Түвшин ширээ		
3	Бичигт Улаан хад	Төв аймаг		
4	Сөнөд	Өвөр Монгол		
5		Булган, Дашинчилэн		
6	Тайхар чулуу	Архангай, Их тамир		
7	Булган уул	Баянхонгор, Өлзийт		
8	Хийдийн гэзэг	Баянхонгор, Өлзийт		
9	Гурван Мандал (Эхэн Мандал)	Баянхонгор, Бууцагаан		
10	Ачит нуур	Баян-Өлгий		
11	Бага газрын чулуу	Дундговь, Дэлгэрцогт		
12	Үзүүр Цохио	Хэнтий Батширээт		
13	Ханангийн бууц	Баянхонгор Галуут		
14	Айр кэникэтэ	Шинжаан		
15	Чаа холь	Тува		
16	Өмнөд Сибир			

оролцож дайн тулаан, хуралдайд оролцдог, өөрийн тамгаа Түрэг, Огузын дунд сийлэх бүрэн эрхтэй бүлэг байжээ. Тэгвэл Донгойн ширээг бүтээх үед энэхүү тамгыг эзэмшигч уг дурсгалд онцгой эрхтэй, тэдэнд зориулсан дурсгал хэмээн үзэж болохоор байна. Түрэгийн Эшир нарын тамга сийлсэн байгаа боловч 6-р гэрэлт хөшөөнд хамгийн оройд нэг удаа, 8-р гэрэлт хөшөөнд Эширийн олон салаа тамганы хувилбарын хамт байгаа бол бусад гэрэлт хөшөөнд янгир тамга мэр сэр сийлсэн боловч тийм ч онцгойрч харагдахгүй байна. Тиймээс тэдний улс төрийн хүчин суларч байсан үед эсвэл зүүн жигүүрийн Монгол

хэлт аймгуудын язгууртны хойдохын ажилд бусад улс, аймаг оролцсон бололтой. Хөшөөнд сийлсэн тамганы хэлхээг ажиглахад хоорондоо угсаа гарлын хамаарал бүхий бүлгийн төлөөлөл хөшөө тус бүрд тамгаа бөөн сийлсэн байна. Эл байдлаас харахад Билгэ хааны тахилын онгоны тамга сийлсэн балбалтай ижилсэхээр сэтгэгдэл төрүүлнэ.

Судлаачид бичмэл “х” үсэг мэт тамгыг саран тамга (тушаатай араараа харсан дан саран) хэмээн нэрлэж буй [Цогтбаатар нар 2017: 46]. Уг тамгыг саран тамгаас үүсэлтэй хэмээн үзвэл хоёр нэмэлт

Саран тамганы хувилбар тамганууд



авсан үүсмэл тамга болох гээд байна. Өөрөөр хэлбэл энгийн сар “С” гэсэн хувилбар үүснэ. Хэрвээ саран тамга уг тамганы анхны махбод мөн бол энэ дурсгалд буй олон саран тамга бүгд эртний угшил нэгтэй аймгууд болох шинжтэй. Гэхдээ энэ дурсгалд буй саран тамга хэлбэрээр дөрвөн ерөнхий хэсэгт хуваагдаж байна. Өөрөөр хэлбэл задгай онгийн ам нь өөд, уруу, зөв, буруу тийш гэсэн дөрвөн дан саран дээр нэмэлт авсан үүсмэл тамганууд байна. Тиймээс бид энэхүү саран тамганы зөв, уруу харсан зэргийг ялгахын тулд өөд харснаас нар зөв тойруулан (А, В, С, D) хэмээн дугаарлаад, дэд бүлгүүдийг (А1, А2, А3) хэмээн дугаарлаж өгөв.

Саран тамганы үүсмэл тамга болох бичмэл “х” үсэг мэт тамга Монголын өндөрлөг нутагт байсан бол ямар нэгэн байдлаар Тан улсын адууны захад ийм тамга бүхий адуу тушаагдаж байсан байх ёстой. Тиймээс одоо бүгдээрээ Тан хуй яо-д эл тамгагай төстэй хувилбар буй эсэхийг сонирхъё. “Тан хуй яо”-г Хятадын Умард Сун улсын ордны түүхч Ван Пү (wang pu - 王溥) НТ 961 онд дэвтэрлэсэн байдаг. Уг сурвалжид Тан улсын үеийн Хуучин, Шинэ Тангийн түүхт огт байхгүй улс төр, эдийн засаг, соёл, түүхийн олон мэдээ агуулснаараа онцлог сурвалж юм. Уг сурвалжид НТ 610-907 оны хооронд Тан улстай харилцаж байсан нүүдэлчин овог аймгийн унаа морьдын онцлог, тамга тэмдэг, түүхэн газар зүйн байршил,

овог аймгийн онцлог зэргийн тухай мэдээ арвин тэмдэглэгдсэн байдаг [Зуев 1960: 93]. Тан улсын түүхэн баримтын эмхэтгэл болох “Тан хуй яо” хэмээх товчоог умардын нүүдэлчдийн адууны тамгыг тэмдэглэсэн итгэмжит нэгэн сурвалж хэмээн ойлгож болно. Уг сурвалжид буй адууны тамга өнөөгийн илэрч буй дурсгал дахь тамгагай нэлээд тохирч одоогоор хэд хэдэн аймгийн тамга тодорхой болоод байгаа билээ. Үүнээс жишээ дурдвал Түрэгийн Эшир, Хөлү [Мөнтулга 2019], Огузын Пүгү (Бухуг) [Пэрлээ 1960], Туфра [Батболд 2017], Эдиз [Мөнхтулга 2018: 124] зэрэг тамга тодорхой болоод байгаа юм. Гэвч уг сурвалжид Татарын адуу хэмээх толгой гарчиг байхгүй. Ер нь энэ үеийн сурвалжид татар, есөн татар, гучин татарын талаар дурдагддаггүй. Судлаачид тэднийг Шивэй аймгийн нэрийн дор тэмдэглэж байсан хэмээн үздэг. Тан Хуй яо-д Шивэй адуу нийлүүлж байсан талаар бас байхгүй байна. Шивэйн талаарх мэдээг бидний үзэж буйгаар тэдэнтэй харьцаж буй худалдаачид, зах хязгаарын цааш түгээгч жижиг наймаачдаас дам мэдээ авч тэмдэглэж байсан хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл Шивэйтэй хил залгаа Татаби, Хятан нар тэдний үслэг эдлэл, адуу мал, түүхий эдийг авч цааш нийлүүлэх буюу зуучилдаг байсан байх талтай. Бидний сурвалжлан буй саран тамгат бүлэг Тан хуй яо-гийн адууны тамга дунд хайж үзэхэд Татаби (Кумоси) нарын адууны тамга дотор байна.

Тан улсад худалдаалж байсан адууны дансанд Хятан, Татаби хоёрын адууны тамга бусдаас олон байгааг хүснэгтээс харж болно. Бидний үзэж буйгаар газар зүйн байрлалын хувьд Тан улстай зүүн хойд талаар нь залгаа хиллэж байсан. Татаби нар умардын нүүдэлчдийн бараа бүтээгдэхүүн, адууг худалдан авч цааш нийлүүлдэг байснаас тэдний адуу хэмээн ойлгож, нийлүүлсэн адууны тамга бүрийг Татаби-тай хамруулан тэмдэглэсэн байх магадлалтай байна. Энэхүү таамгийг батлахуйц мэдээ Тан Хуй яо-д тушааж байсан адууг тодорхойлон бичсэн дотор сонирхолтой мэдээ байна. Түрэг агттай Хятан болон Татаби агт адил нэг угшилтай гэхдээ Түрэг агтыг бодвол жижиг биетэй боловч ойд явж чаддагаараа давуутай Татаби агт жижиг биетэй боловч шөрмөс сайтай [唐会要. 卷七二. 1308]. Хятан, Татаби нар Шивэй-Татарын агтыг дамжуулан нийлүүлж байсны нэгэн баримт байж болох юм. Учир нь Шивэй-Татарууд ой, ойт хээрийн бүс хосолсон нутагт суурьшин байсан тул тэдний агт ойд сайн явах чадвартай, шөрмөс сайтай байсныг ийнхүү тэмдэглэсэн бололтой байна.

Татаби нар 5 аймагтай хэмээн тэмдэглэдэг хэрнээ тушааж байсан адууны тамга нь 8-9 тамгыг тэдэнд хамруулан тэмдэглэсэн байна [罗丰 2010: 117-149]. Татаби-ийн 5 аймаг хоорондоо ойролцоо тамгатай байсан хэмээн үзэж байна. Тэдний адууны тамгын эхний хоёр тамга хоорондоо маш төстэй байгаа бөгөөд эдгээр тамга л Татаби нарт хамаатай болов уу. Харин жагсаалтын 6, 9-т буй тамга бидний Шивэй-Татар тамга хэмээн үзэж буй саран тамганы А, В хувилбарын тамгадтай адил байна. Мөн энд буй Монгол бичгийн “Б” үсэгтэй адил тамга нь бидний сэргээн зурсан “ф” С2 бүлгийн саран онги бүхий тамга ийм байдалтай зурагдсан байж болохоор байна. Татаби-д хамааралтайгаар тэмдэглэгдсэн 5 дахь алх мэт “人” тамга бидний А1 хэмээх бүлэгт оруулсан “フ” тамга бага зэрэг хазайн тэмдэглэгдсэн байдалтай байгаа бололтой. Хятан нарын тушааж байсан адууны тамга мөн адил олон байгаа юм. Хятан нар анх төр байгуулахад уугуул найман аймаг нийлэн байгуулсан түүхтэй тиймээс Хятанд олон тамга байхыг үгүйсгэхгүй. Бидний үзэж буйгаар Хятан, Татаби хоёрын тамга дунд бидний Шивэр-Татар

тамганууд байна хэмээн үзэж байна. Ялангуяа Татаби дотор Татар тамга лавтай “人”, “亼”, “兆” хэлбэртэй тамгыг “フ, 𠂇, 𠂈” саран тамганы хувилбарууд мөн хэмээн үзэж байна.

Донгойн ширээний дурсгал бол эртнээс урагш, хойш явсан замын дагуу байгуулагдсан дурсгал юм. Уг замыг өмнө талд нь тосон хааж суусан нь Татаби нар юм. Өөрөөр хэлбэл өнөөгийн Сүхбаатар, Дорноговьтой хил залгаа Өвөр Монголын нутаг юм. Энэ нь ч түүхэн газар зүйн баримтаар батлагдсан байршил юм. Үүгээр зарим Шивэй-Татарын үслэг эдлэл, түүхий эд, мал амьтан дамжин өнгөрдөг байсан бол үүнээс арай зүүн тийш Хянганы уулсаас буусан замыг Хятан нар тоссон байдалтай зарим Шивэй, Мохэ нарын бараа бүтээгдэхүүн дамждаг байж, Хар балгасаас урагш ӨМӨЗО-ны Бугат руу чиглэсэн замаар Түрэг, Уйгур нар голдуу нааш цааш зорчиж байсан байж болох дүр бууж байна. Донгойн Ширээн дурсгал нь Татарын ихэс дээдэст зориулсан тахилын онгон болохыг саран тамгаар нь тогтоож байна хэмээн үзэж болно. Үүнээс гадна түүхэн газар зүйн хувьд энэхүү боломжийг өндөр болгож өгч байгаа юм. Мөн уг дурсгал Х зууны эхэн хүртэл лавтай бүтэн байсан нь бас нэгэн баталгаа хэмээн үзэж байна. Харь аймгийн эд биш байж гэдгийг харуулж байна. Хэнтий, Сүхбаатар аймгийн орон нутаг судлах музейгээс явуулсан орон нутгийн соёлын өвийг бүртгэл, хайгуул судалгааны үеэр Донгойн ширээтэй төстэй тахилын онгон хэд хэд илэрснээс гадна ялангуяа Хэнтий аймгийн нутагт Түрэгийн үеийн хүн чулуут тахилын онгоноос хэд хэдэн шинжээр ялгарахуйц хүн чулуут дурсгалууд илрээд байна. Түрэг, Уйгурын үед нутгийн зүүн жигүүрийн Монгол хэлт Татар аймгууд тэдэнтэй адил хүн чулуу, тахилын онгон босгох соёл байсан ажээ. Татарын тахилын онгон түрэгээс бага зэргийн ялгаатай үйлдэж байсан нь ийнхүү ялгарч байна [Цогтбаатар нар 2017: 110]. Жишээ нь хүн чулуунд хүнийг гөхөл гээгтэй, балбалгүй гэх мэт.

Татаби дотор байгаа саран тамганы хувилбаруудыг сайн сэргээвэл таван тамга сартай хамаатай бололтой харагдаж байна. Үүнээс “亼”, “兆”, “人” сэргээж харахад хялбар буй бөгөөд 7, 8 –д буй хоёр дүрслэл Билгэ хааны тахилын онгон балбал дээр буй тамга болох “𠂇”, “𠂈” ийм

契丹 qidan	Хятан	兆父特女旁	兆虫特女旁	兆虫特女旁	兆虫特女旁	兆	兆
奚 xi	Си	𠂇𠂇𠂇𠂇	𠂇𠂇𠂇𠂇	𠂇𠂇𠂇𠂇	𠂇𠂇𠂇𠂇	𠂇	𠂇



Кара Ногай Мангыт урув \уруг\	Рашаан хад	Чуваш Кипчак Куп \хувь\чуваш	Унгарт	Сармат	Башкир
х х̄	ᠬ ᠬ̄ ᠬ	ᠬ	ᠬ ᠬ̄ ᠬᠮ	ᠬ	ᠬ

хувилбаруудтай адил хэмээн сэргээж болохоор байна.

Донгойн ширээний тамганы В1 хувилбар тамга нь Монголын баруун нутгаар Түрэг-Уйгурын үеийн нэг доор сийлсэн олон тамгат дурсгал дунд хэд хэдэн газарт тэмдэглэсэн нь тохиолдож байгаа юм. Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Гурван Мандал уулын Эхэн Мандалд, Өлзийт сумын Хийдийн гээг, Өлзийт сумын Булган ууланд, Архангай аймгийн Тайхар чулуунд, Бага газрын чулуу, Ачит нууранд В3 хамт гэх тохиолдлууд бий. Үүнээс гадна Алтайн баруун талд Казахстаны нутагт мөн тэмдэглэгдсэн байна [Рогожинский 2012: 91]. Харин Донгойн ширээний дурсгал дахь “ᠬ” А1 хувилбар тамганы үүсмэл тамганууд Енисейн сав газрын дурсгалуудад А1а түүний салбар салаа тамганууд буй нь Татарын нүүдэл Жужанаас магадгүй түүнээс ч өмнө өрнө рүү нүүдэллэж байсныг судлах баримт болж болох юм. Энэхүү тамгатай хамт сийлэгдсэн бусад тамгуудаас харахад Түрэг, Огузын голдуу тамгатай хамт сийлэгдсэн байгаа нь Татарын тамга мөн хэмээхийг батлахуйц нэгэн баримт бөгөөд Уйгурын хаант улсыг байгуулах үйлсэд Огуз-Татарын холбоо хавсран Түрэгийн төрийг самууруулсан юм. Уйгурууд хаант улсыг байгуулсны дараа өөрсдийн холбоот Басмил, Карлуктай мөн дайсагналцах болсон. Эл тулаанд Уйгурын талд Байырку-Татарууд оролцсон байдаг. Энэ талаар Моюунчурын гэрэлт хөшөөнд дурдсан байна. Тиймээс баруун тийш аян дайнд Татар-Огузын холбооны хүчин товлосон газарт хуран чуулж ийнхүү өөрсдийн тамгыг сийлсэн гэх үндэс байна.

Академич Х.Пэрлээ гуай “х” үсэг мэт тамгыг бусад дурсгалтай харгуулан үзэж Кипчак Чуваш, Унгур, Башкир зэрэг нутагт илэрсэн тамгатай төстэй буйг дурдсан байна.

Түүний харьцуулан үзсэн баримтад тулгуурлавал Ногайчуудын дунд Татарын хэсэг бусад оролцож явсан байж болох юм. Тэдний тамга нь Татар хэмээн үзэж буй тамганы хувилбартай адил байгаа нь нэлээд сонирхолтой байна. Овгийн тамганы үндэс нь нэг л зурлага дүрсээс үүссэн

байдаг, харин тамга дам үүсгэхдээ олон янзын цэг, зураас, хээ угалз нэмдэг байжээ [Пэрлээ 1976:3]. хэмээн тэмдэглэсэн байна. Энэхүү тамга саран тамгаас үүсэж хос сар, тэгээд чагт гэх мэтээр үүссэн байж болох талаар дээр өгүүлсэн билээ. Татарын олон аймаг салаалах тусам уг тамга олон нэмэлттэй болж байсан нь дамжиггүй бөгөөд Жужаны үед хэдийн “х” хэлбэрээ олсон байсан байж болох юм. Учир нь Унгарт энэ тамга яг адил байгаа учир Жужаны хаант улсын өрнө рүү хийсэн нүүдэлтэй холбоотой байхыг үгүйсгэхгүй юм.

#### Төгсгөл

Овгууд шинээр салбарлах тутам овгийн үндсэн тамганы дүрсэнд нэмэлт хийж үүсгэмэл тамга нэмэгдэхийн хамт шинэ үндсэн тамга ч гарган овгийн тамга олширч олон овгийн их хуралдай цуглаанд ирэгчид нийгэм олноор хэрэглэх ус бэлчээрийг эзэмших, эдлэх эрхээ бататган энд тэндхийн хад чулуунд, нэгэн дор овгийн тамгаа сийлэн үлдээх явдал байжээ [Пэрлээ 1976:9]. Үүнээс гадна аян дайны үед товлосон газарт тамгаа сийлэх, оршуулгын ёслолд оролцсоны тэмдэг болгож тамгаа сийлдэг байж. Донгойн ширээн дурсгал нь Татар аймгийн дурсгал мөн байна. Түрэгийн хаант улсын төгсгөл үед татарын холбоо өндийж хүчирхэгжиж байсны илрэл хэмээн үзэж байна. Уйгурын хаант улс байгуулах үйлсэд тэд идэвхийлэн оролцох болсон нь түүх сурвалжид цухас дурдагддаг. Тиймээс Татарууд нутгийн зүүн бүсэд өөрсдийн төр улсын уламжлалыг аймгийн холбооны хүрээнд хадгалж, өөрсдийн онцлогтой дурсгалууд үйлдэж байжээ.

**Ном зүй**

**Мөнхтулга 2015** – Мөнхтулга Р. Донгойн Ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан нь. Эртний Түрэгийн түүх, соёл. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2015. Тал. 21-55

**Мөнхтулга 2013**- Мөнхтулга Р., Т.Осава. Донгойн Ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан тухай тайлан. УБ, 2013.

**Эрдэнэ-Очир нар. 2016** – Эрдэнэ-Очир Н., Болорбат Ц., Лхүндэв Г. “Донгойн ширээ”-н дурсгалын археологийн малтлага судалгааны шинэ үр дүнгээс. Монголын зүүн бүс нутгийн археологийн дурсгалын хадгалалт, хамгаалалт. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2016. Тал. 249-257.

**Такаши Осава 2016** – Такаши Осава. Монголын зүүн бүс нутгийн “Донгойн ширээ”-ний дурсгалын эртний Түрэгийн түүх, археологийн судалгаанд эзлэх байр суурь, ач холбогдлын тухай. Монголын зүүн бүс нутгийн археологийн дурсгалын хадгалалт, хамгаалалт. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2016.

**Напил 2009** – Напил Б. Эртний Түрэгийн хаант төрийн удирдлага дахь цол хэргэмийн асуудалд. “Оюуны хэлхээ”. №1 (03), УБ, 2009. Тал. 5-20.

**Дорж 1975** – Дорж Д., Новгородова Э.А. Петроглифы Монголии. УБ, 1975.36, 224-228.

**Самашев 2010** – Самашев З., Базылхан Н., Самашев С. Древнетюркские тамги. Алматы, 2010.59-60.

**Галдан 2010** – Галдан Г., Жаргалан Б. Бага газрын чулууны хадны зураг дахь тамга тэмдгийн дүрслэл. – SA Tom. (IX) XXIX, fasc. 10. УБ, 2010. 174-185

**Dalan Gurib 1999** – Dalan Gurib Na. Inner Mongolia art of rock carvings. 内蒙古文化出版社. 1999年. 163-164.

苏北海. 新疆岩画. 新疆美术摄影出版社. 1994.424-434

**Цогтбаатар нар. 2017** – Цогтбаатар Б., Эрдэнэ-Очир Н., Осояа Т., Лхүндэв Г., Ш.Шато, Батдалай Б., Амарболд Э., Ангарагдөлгөөн Г. “Донгойн ширээ”-ний дурсгалын археологийн судалгаа. УБ, 2017. 46

**Мөнхтулга нар. 2019** – Мөнхтулга Р., Бүрэнтөгс Г., Арьяажав Б. Талын хөшөөний тахилын онгон. УБ, 2019

**Пэрлээ 2012** – Пэрлээ Х. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. Х.Пэрлээ. Бүтээлийн чуулган II.УБ, 2012.5-243;

**Зуев 1960** – Зуев Ю.А. Тамги лошадей из вассальных княжств. Алма-Ата: Академия наук Казахской ССР 1960., стр 93.

**Батболд 2017** – Батболд Г. Мартагдсан Пүгү аймаг. УБ, 2017

**Мөнхтулга 2018** – Мөнхтулга Р. A newly-found runic inscription from Ikh Nart. Түрэг, Монгол судлалын өгүүллүүд УБ,2018.124

**Цогтбаатар нар. 2017** – Цогтбаатар Б. Хан Хэнтий өв соёлын дээжис. УБ,2017.110

**Рогожинский 2012** – А.Е.Рогожинский. Тамги-петроглифы средневековых кочевников Казакстана: Итоги новейших исследований и перспективы дальнейшего изучения. Историко-культурное наследие и современная культура. Алматы 2012.91-104

**Х.Пэрлээ 1976** – Пэрлээ Х. Монгол түмний гарлыг тамгаар судлах нь. УБ, 1976, 9

**Монголын археологи:** Хээрийн судалгааны тайлан III (1979-1983). УБ, 2016. 361


罗丰 2010 – 罗丰. 规矩或率意为? — 唐帝国的马印. 唐研究. 第16卷. 北京2010年. 117-149  
唐会要. 卷七二. 1308 页.




Зураг 1. Сүхбаатар аймаг Дарьганга сум Хөндлөн хавцал. Д.Баяр 1984 он



Зураг 2. Сүхбаатар аймаг Дарьганга сум Хөндлөн хавцал. Сүхбаатарын орон нутаг судлах музей. 2021 он



Зураг 3. Донгойн ширээний №5 хөшөө



Зураг 4. Донгойн ширээний №1 хөшөө